

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ
ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Л.ЦЭНГҮҮНЖАВ ТАНАА

2020.03.06 № 06/735
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
2.9.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.10.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	7
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.13.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3.	Менежментийн захидал.....	8
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2.	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3.	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4.	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	14

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Л.Цэнгүүнжав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 10-наас 3 дугаар сарын 04-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөж, тус компанийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторын туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг тус компанид 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийг олон улсын зангилаа болгон эдийн засгийн чөлөөт бүс байгуулах"-д оршино.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шинэ нисэх буудлын менежмент хэрэгжүүлэх хамтарсан компанийн 49.0 хувийг эзэмших, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах;
- Нисэх буудлаар үйлчлүүлэгчдэд олон улсын стандарт, шаардлагын түвшинд хүрсэн, аюулгүй байдлыг хангасан, тав тухтай нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх;
- Нисэх буудлын хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх замаар Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, ашигтай ажиллагааг хангуулах.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,307.8 сая төгрөгөөс тооцон 13.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшингийн тооцоололд өөрчлөлт ороогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,189.1 сая төгрөгөөр буюу 66.2 хувиар өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, эзэмшигчийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,235.1	10,133.3	(17,101.8)
Авлага	0.0	0.5	0.5
Урьдчилгаа	0.2	9.4	9.2
Бараа материал	-	5.6	5.6
Үндсэн хөрөнгө	227.8	213.1	(14.8)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	35,290.6	35,290.6
Нийт хөрөнгө	27,463.2	45,652.4	18,189.2
Өр төлбөр	0.6	1.4	0.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	27,462.6	45,651.0	18,188.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	27,463.2	45,652.4	18,189.2

Мөнгөн хөрөнгө 17,101.8 сая төгрөгөөр буурсан нь тус компани нь Засгийн газрын 175 дугаар тогтоолын дагуу Монгол-Японы хамтарсан компанийн 49.0 хувийг эзэмших зориулалтаар 2018-2019 оны байдлаар нийт 35,290.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай 5.6 сая төгрөгийн бичиг хэргийн, хангамжийн материал худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 227.8 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд хөрөнгө оруулалтаар 18.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 33.7 сая төгрөгийн элэгдэл тооцож, оны эцэст 213.1 сая төгрөг болжээ.

Урт хугацаат хөрөнгө оруулалт өссөн нь тус компани нь Засгийн газрын 175 дугаар тогтоолын дагуу Монгол-Японы хамтарсан компанийн 49.0 хувийг эзэмших зориулалтаар эхний ээлжинд 35,290.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 0.6 сая төгрөг байсан бөгөөд 0.7 сая төгрөгөөр өссөн нь татвар, цалингийн өр нэмэгдсэнтэй холбоотой.

Урьдчилж төлсөн тооцоо дансны эхний үлдэгдэл 0.2 сая төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 9.2 сая төгрөгөөр өссөн нь компанийн байрны түрээсийн барьцаагаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 45,651.0 сая төгрөг болж 18,188.5 сая төгрөгөөр өссөн нь 2019 онд Засгийн газрын 175 дугаар тогтоолын дагуу ИНЕГ-аас Монгол-Японы хамтарсан компанийн 0.49 хувийг эзэмших зориулалтаар хүлээлгэн өгсөн 17,647.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтэй холбоотой байна. Тайланд хугацаанд нийт 541.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2.9. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл тодорхойлж, 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн материаллаг бус алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажилласан байдал буюу тус компанийн анхан шатны баримт хөтлөлтийн талаар авсан арга хэмжээг дахин хянаж үзнэ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авалт түүний гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгч, зөвлөмжийн биелэлт 100.0 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Хүчингүй болсон Санхүү, Эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 дугаар тушаал, Санхүү, Эдийн засгийн сайдын 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 182 дугаар тушаалуудаар тус тус баталсан анхан шатны баримтуудаар нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар шинэчлэгдэн баталсан анхан шатны баримтуудаар хөтөлж байх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн холбогдох заавар, журмыг мөрдөөгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Маягт, заавар батлах тухай" журмыг тус тус мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,235,348,572.35	10,148,726,698.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,235,099,343.36	10,133,255,619.88
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	378,221.00	208,359.00
31110	Төгрөг	378,221.00	208,359.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	27,234,721,122.36	10,133,047,260.88
3121	Төгрөг	27,234,721,122.36	292,216,252.02
31213	Арилжааны банк дахь харилцах	27,234,721,122.36	292,216,252.02
3122	Гадаад валют	-	9,840,831,008.86
31223	Арилжааны банк дахь харилцах	-	9,840,831,008.86
33	АВЛАГА	34,999.99	526,666.67
33401	Дансны авлага /ТӨҮГ/	34,999.99	526,666.67
34	УРЬДЧИЛГАА	214,229.00	9,374,816.00
34600	Урьдчилж гарсан зардал	214,229.00	9,374,816.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	5,569,596.00
354	Хангамжийн материал	-	5,569,596.00
35470	Бусад хангамжийн материал	-	5,569,596.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	227,838,151.05	35,503,655,969.24
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	35,290,578,514.07
372	Үнэт цаас	-	35,290,578,514.07
37210	Төгрөг	-	35,290,578,514.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	227,838,151.05	213,077,455.17
392	Биет хөрөнгө	227,838,151.05	213,077,455.17
39203	Авто-тээврийн хэрэгсэл	188,370,000.00	188,370,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	5,934,945.20	29,481,195.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	34,194,000.00	43,374,926.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	2,759,333.20	11,385,112.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,453,420.00	24,252,210.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	484,990.55	2,053,372.86
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	27,463,186,723.40	45,652,382,667.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	635,418.47	1,379,365.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	635,418.47	1,379,365.00
413	Өглөг	635,418.47	1,379,365.00
4136	Бусад өглөг	635,418.47	1,379,365.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,647.62	
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	629,770.85	210,473.72
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		1,168,891.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,462,551,304.93	45,651,003,302.79
51	Засгийн газрын хувь оролцоо	27,462,551,304.93	45,651,003,302.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	27,626,446,000.00	45,273,410,521.60
51101	Өмч: - төрийн	1,000,000.00	1,000,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	27,625,446,000.00	45,272,410,521.60
512	Хуримтлагдсан үр дүн	(163,894,695.07)	377,592,781.19
51210	Өмнөх үеийн үр дүн		(163,894,695.07)
51220	Тайлант үеийн үр дүн	(163,894,695.07)	541,487,476.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	27,463,186,723.40	45,652,382,667.79

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,291,591.21	1,155,107,560.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,291,591.21	1,155,107,560.49
120	Нийтлэг татварын бус орлого	9,291,591.21	1,155,107,560.49
120002	Хүүгийн орлого	7,780,127.21	693,950,378.49
120009	Бусад орлого	1,511,464.00	461,157,182.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	173,186,286.28	613,624,066.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	173,186,286.28	613,624,066.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	173,186,286.28	613,624,066.77
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	173,186,286.28	613,624,066.77
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	172,408,273.57	544,229,029.08
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	778,012.71	69,395,037.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(163,894,695.07)</u>	<u>541,483,493.72</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	3,982.54
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		3,982.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	3,982.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(163,894,695.07)</u>	<u>541,487,476.26</u>

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>27,626,596,000.00</u>	<u>18,108,746,217.60</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,626,596,000.00	18,108,746,217.60
120	Нийтлэг татварын бус орлого	27,626,596,000.00	18,108,746,217.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,626,446,000.00	17,646,964,521.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,626,446,000.00	17,646,964,521.60
120009	Бусад орлого	150,000.00	461,781,696.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>163,584,463.85</u>	<u>594,986,072.04</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,584,463.85	594,986,072.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163,584,463.85	594,986,072.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,699,450.54	214,810,162.85
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	87,699,450.54	214,810,162.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,861,708.90	66,572,074.79
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	21,861,708.90	66,572,074.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,498,000.00	74,194,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	23,498,000.00	74,194,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,717,667.00	32,319,246.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		10,374,482.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	7,717,667.00	21,944,764.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,807,637.41	207,090,588.40
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	9,654,548.03	96,666,176.77
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	180,000.00	1,260,000.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	12,973,089.38	109,164,411.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>27,463,011,536.15</u>	<u>17,513,760,145.56</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	7,780,127.21	693,950,378.49
140007	Хүлээн авсан хүүний орлого	7,780,127.21	693,950,378.49
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	235,692,320.00	35,309,558,230.07
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	235,692,320.00	35,309,558,230.07
2200	Дотоод эх үүсвэрээр	235,692,320.00	35,309,558,230.07
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	235,692,320.00	18,979,716.00

225103	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		35,290,578,514.07
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(227,912,192.79)</u>	<u>(34,615,607,851.58)</u>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	3,982.54
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		3,982.54
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>3,982.54</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	27,235,099,343.36	(17,101,843,723.48)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	27,235,099,343.36
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,235,099,343.36	10,133,255,619.88

4.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Эздийн өмчийн бусад хэсэг	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдаа	0.00	0.00	0.00	0.00
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00
4	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	(163,894,695.07)	27,625,446,000.00	27,642,551,304.93
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,000,000.00	(163,894,695.07)	27,625,446,000.00	27,462,551,304.93
6	Тайлант үеийн үр дүн		541,487,476.26	17,646,964,521.60	18,188,451,997.86
7	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	377,592,781.19	45,272,410,521.60	45,651,003,302.79

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн</i>	Аудитын код:
2020			САГ-2020/85/СТА-ТӨХХК
Шалгагдсан байгууллагын нэр:	“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог, нэр
	1	2	3	4	5
1	Хүчингүй болсон Санхүү, Эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан анхан шатны баримтуудаар нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг тус тус зөрчиж байна.	0.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Цэнгүүнжав Ё.Мөнхбаяр

